

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ
НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАНГИЙН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2025/01/НА-СТА-ТЕЗ/

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Аудитор Ж.Угтахбаяр

Аудитор Д.Должинсүрэн

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2025/01/НА-СТА-ТЕЗ	Аудитын хамрагдах хугацаа:	2024 он
Аудитын нэр:	“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын 1-р нэгж Аудитор Ж.Угтахбаяр, Д.Должинсүрэн

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/108 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймгийн Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
Аудитын зорилт:	➤ Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх; ➤ Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, хууль, журмын дагуу зарцуулсан эсэх; ➤ Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд хүрсэн эсэх.
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	❖ АДБОУС ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020 ❖ Монгол Улсын Үндсэн хууль; ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; ❖ Төсвийн тухай хууль; ❖ Төрийн аудитын тухай хууль; ❖ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль; ❖ Татварын багц хуулиуд; ❖ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль; ❖ Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.
Аудитын хамарсан хүрээ:	Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 15 сумын төсвийн гүйцэтгэлийн тайлан, татварын мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, аймгийн болон сумдын орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан
Аудитын арга зүй:	АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүй

Хоёр. Аудитын үр дүн

А. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 30.7 хувиар давсан боловч 4 нэр төрлийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс тасарсан байна.



Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль болон аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн нийт орлогыг 70,891.9 сая төгрөгөөр баталсан байна. Харин 2024 оны 09 дүгээр сард Монгол Улсын Их Хурал, аймаг, сумдын ИТХ-аар төсвийн нийт орлогыг дахин тодотгож 93,184.1 сая төгрөг байхаар нэмэгдүүлэн баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 Орон нутгийн орлогын анхны төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө /сая.төг/

Эх үүсвэр		2023 оны төлөвлөгөө	2024 он		
А		1	төлөвлөгөө 2	тодотгосон 3	зөрүү 4=3-2
Улсын төсвөөс	ОНХС	11,875.4	15,244.5	15,880.4	635.9
	Санхүүгийн дэмжлэг	16,965.5	27,040.9	18,195.6	(8,845.3)
Орон нутгийн төсвөөс	Татварын болон татварын бус орлого	15,566.4	17,028.1	40,955.7	23,927.7
	ОНЕО-ын үлдэгдэл	2,357.3	1,709.8	8,049.6	6,339.8
	Төвлөрүүлэх орлого	3,153.7	2,177.9	3,564.9	1,387.0
	Урьд оны үлдэгдэл	6,979.6	7,690.7	6,537.8	(1,152.9)
дүн		56,897.9	70,891.9	93,184.1	22,292.2

Орон нутгийн төсвийн орлогыг нэмж тодотгоход дараах орлогууд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
2. Үйл ажиллагааны орлого;
3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварууд байна.

Аймгийн хэмжээнд 4 нэр төрлийн орлогыг материаллагаар нэмж тодотгон, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулж тодотгох нөхцөлийг бий болгосон байна.



Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар /шинэчлэн найруулсан/ Дундговь аймагт нийт 34,076.0 сая төгрөг олгохоос орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 545.5 сая төгрөгөөр дутуу, санхүүгийн дэмжлэг 18,195.6 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

ТЕЗ-ийн нийт орлогыг 93,184.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр нийт 110,809.7 сая төгрөгийг төвлөрүүлэн 3.9 хувиар давуулсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Орлогын эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн	
				дүн	хувь
1	ОНХС	15,880.4	15,334.9	545.5	96.6
2	Санхүүгийн дэмжлэг	18,195.6	18,195.6	-	100.0
3	Татварын болон татварын бус орлого	40,955.7	59,399.7	(18,444.0)	145.0
4	ОНЕО үлдэгдлээс	8,049.6	8,314.2	(264.6)	103.3
5	Төвлөрүүлэх орлого	3,564.9	2,529.3	1,035.6	71.0
6	Урьд оны үлдэгдэл	6,537.8	7,035.9	(498.1)	107.6
	Дүн	93,184.1	110,809.7	(17,625.6)	103.9

Орон нутгийн орлогыг оны эцэст гүйцэтгэлээр 77,279.2 сая төгрөгийг төвлөрүүлж, тодотгосон орлогоос 18,171.1 сая төгрөг, анх батлагдсанаас 47,578.0 сая төгрөгөөр давуулсан байна. Энэ нь тайланд онд нэг удаагийн шинжтэй орон нутгийн орлогын зарим нэр төрлийн орлого давж биелсэнтэй холбоотой байна. Харин хүүгийн орлогын 629.0 сая төгрөгийг ямар эх үүсвэрээс төвлөрүүлэх нь тодорхойгүй, бодит тооцоо, судалгаанд үндэслэлгүй баталснаас огт биелээгүй байна. Иймд орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл, статистик тоон мэдээнд үндэслэн бодитоор төлөвлөх шаардлагатай байгааг харуулж байна.

Төсвийн шууд захирагчдын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар орон нутгийн өмчийг бусдад түрээслүүлснээс бий болсон орлогын хувийг орон нутагт төвлөрүүлээгүй, татварын зарим

нэр төрлийн орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлээгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд өгсөн хандив тусламжийг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй зөрчлүүд илэрсэн.

Иймд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад нийтлэг гарч байгаа орон нутгийн өмчийн түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлэн, Баянжаргалан сум уул, уурхайн компаниас авсан хандив, замын хураамжийн орлогыг төрийн бус байгууллагаар дамжуулан авч өмнөх аудитаар хүрүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул ТЕЗ-д албан шаардлага хүргүүлсэн.

Мөн Сайнцагаан, Луус, Дэрэн, Гурвансайхан, Адаацаг сумд орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт 405.0 сая төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын дансаар авч зарцуулсан зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүллээ.

Б. Төсвийн нийт зардлыг төлөвлөж, зарцуулахдаа сангийн яамнаас өгсөн чиглэлийг тусгасан ч төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.



Дундговь аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор аймгийн 2024 оны төсвийн зарлагыг 71,986.5 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 40 дугаар тогтоолоор 21,197.6 сая төгрөгөөр нэмж тодотгон 93,184.1 сая төгрөг байхаар батлагдсан байна.

Хүснэгт №3 Төсвийн зардлын өмнөх он, анх батлагдсан, тодотгосон төлөвлөгөө, харьцуулалт /сая.төг/

Э/З ангилал	Өмнөх он	Тайлант он		Зөрүү	
		2023 оны №46 тогтоол	2024 оны №40 тогтоол	Өмнөх оноос	Анхны батлагдсан
Урсгал зардал	30,749.5	39,710.9	45,594.6	14,845.08	5,883.7
Хөрөнгийн зардал	23,355.8	30,011.7	45,313.6	21,957.8	15,302.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	2,792.5	2,264.0	2,275.9	-516.7	11.9
Нийт дүн	56,897.8	71,986.5	93,184.1	36,286.3	21,197.6

Төсвийн нийт зардлыг нэмэгдүүлсэн нь төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл, орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг олгохоор нэмж тооцсонтой холбоотой байна.



Дундговь аймгийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг 93,184.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 68.2 буюу 63,519.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 48.9 хувийг урсгал зардал, 48.6 хувийг хөрөнгийн зардал, 2.4 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Хүснэгт №4 Төсвийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Урсгал зардал	45,594.6	41,162.3	4,432.3	90.3
Хөрөнгийн зардал	45,313.6	22,267.1	23,046.5	49.1
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,275.9	90.0	2,185.8	4.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	93,184.1	63,519.5	29,664.6	68.2

УРСГАЛ ЗАРДАЛ

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 37 төсөвт байгууллагад 2024 онд нийт 514 төрийн албан хаагчийн орон тоонд 13,589.6 сая төгрөгийн цалин урамшууллын зардал батлагдсан байна. Гүйцэтгэлээр 456 албан хаагч ажиллаж, нийт 13,073.2 сая төгрөгийн цалин, нэмэгдэл урамшуулал олгогдсон бөгөөд сул орон тооны 58 албан хаагчийн 516.4 сая төгрөгийн цалин үлдсэн байна.

Сул орон тоо нь нийт батлагдсан орон тооны 11.3 хувийг эзэлж байна. Үүний 74.1 хувь буюу 43 нь төрийн захиргааны албан хаагч байгаа нь орон нутагт мэргэжлийн боловсон хүчний хомсдол бий болсонтой холбоотой байна.

Татаас: Нийт татаасны 98.2 хувь буюу 2,072.4 сая төгрөгийг орон нутгийн өмчит байгууллагуудад 1.8 хувь буюу 36.6 сая төгрөгийг аймгийн өрхийн эмнэлгүүдэд олгохоор батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн өмчит байгууллагуудад 2,072.4 сая, өрхийн эмнэлгүүдэд 36.6 сая төгрөгийн татаасыг олгосон байна. Цэвэр, бохир усны байгууламжуудын байгууллагын хэлбэр, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь тодорхойгүй Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Гурвансайхан сумдад цэвэр, бохир усны байгууламж байгуулан нийт 140.9 сая төгрөгийн татаас олгосон байна. Иймд ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн үйл ажиллагааны нэгтгэсэн бодлого, стратегийг бий болгон, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангуулж, өөрийн орлоготой, үйлчилгээний төлбөртэй байх тогтолцоог нэвтрүүлэн, бүсчилсэн байдлаар төвлөрсөн удирдлагатай хамгийн боломжит зөв зохион байгуулалтын хэлбэрийг олж, шийдвэрлэх шаардлагатай байна.

Урсгал шилжүүлэг: Төрийн захиргааны албан хаагчид олгох “Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг”-ийн зардлын төсвийг 782.0 сая төгрөгөөр баталснаас 779.6 сая төгрөг буюу 99.7 хувийг олгосон байна.

Аймгийн хэмжээнд 31 байгууллагын 97 албан хаагчид 779.6 сая төгрөгийн дэмжлэгийг олгохдоо 29 байгууллагын 93 албан хаагчийн 724.1 сая төгрөгийн дэмжлэгээс 72.4 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй байна.

Иймд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгээс Хувь хүний орлогын албан татварыг суутгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр боллоо.

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

2024 оны байдлаар Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгийн зардлын гүйцэтгэл 49.1 хувьтай буюу 23,046.5 сая төгрөгийн зардал дутуу зарцуулсан байна.

Хөрөнгийн зардалд дараах зардлууд багтсан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС), Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөг 22,378.1 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 13,725.2 сая төгрөг буюу 61.3 хувь нь зарцуулагдсан байна
- Орон нутгийн хөрөнгө оруулалт (ОНХО), Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 6,403.1 сая төгрөгийн өртөгтэй 37 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг аймгийн ИТХ-ын тогтоолоор тодотгол хийж, нийт 22,471.9 сая төгрөгийн 86 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж, анхны төлөвлөгөөнөөс 3.5 дахин нэмэгдүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар ОНХО-г шалгахад 1 дутуу хэрэгжсэн ТАХ-нд олгосон 53.3 сая төгрөгийг авлагаар тайлагнаагүй зөрчил илэрч, аудитын явцад зөрчлийг арилган, авлагаар тайлагнуулсан байна.

Орон нутгийн шинэ удирдлагуудаас төсөл хэрэгжүүлэх цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал бий болсноос 11,345.4 сая төгрөгийн 30 ТАХ зогсоосон. Тухайн ТАХ-үүдийн зураг, төсвийг дахин нягталж, шаардлага хангасан ТАХ-г 2025 онд шилжүүлж, хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ

Эргэн төлөгдөх зээлийн төлөвлөгөөг 2,275.9 сая төгрөгөөр баталснаас 4 хувь буюу 90.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2024 онд “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээл олгосон байдал хангалтгүй байна. Энэ нь Засгийн газраас 2024 онд “Шинэ хоршоо” хөдөлгөөн зохион байгуулсантай холбоотой Дундговь аймагт шинээр 552 хоршоо байгуулагдаж, 480 хоршооны 1621 гишүүн малчдад 54,886.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосонтой холбоотой зээлийн хүсэлт ирээгүй. Мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн шалгуур өндөр, уян хатан бус байгаа нь хоршоодыг зээлд хамрагдах боломжгүй

болгож, улмаар хөрөнгө гацах, эргэлтгүй болох эрсдэл үүсгэж байна. Иймд Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг өөрчлөн зөвхөн хоршоонд бус, тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдэд зээл олгох боломжийг бий болгох талаар ҮАГ-аар дамжуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад уламжлахаар боллоо.

Төрийн хэмнэлтийн тухай хууль: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 370.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 287.5 сая төгрөгийн 28 хугацаатай албан шаардлага, 23.8 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 58.9 сая төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Нийт илэрсэн зөрчлийн 77.6 хувийг цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс 248.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил эзэлж байна. Өмнөх аудитаар өгсөн цахим худалдан авалттай холбоотой зөрчил өссөн тул зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр боллоо.

Шилэн дансны тухай хууль: Аудитаар шилэн дансны цахим хуудсанд санхүүжилтийн орлого, зарлага, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг 80-95 хувьтай мэдээлсэн 7 байгууллагад зөвлөмж, 79 ба түүнээс доош хувьтай мэдээлсэн 6 байгууллагад зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй 2 байгууллагын 3 албан тушаалтанд хариуцлага тооцох хугацаатай албан шаардлагыг тус тус хүргүүлэн ажиллажээ.

В. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 85.2 хувьтай дүгнэгдэж, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 158 төсөл, арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, хэрэгжүүлснээс 125 арга хэмжээ үр дүнтэй, 9 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 6 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 18 арга хэмжээ огт хэрэгжээгүй, жилийн эцсийн байдлаар 85.2 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна. Энэ нь ОНХО-ын хэрэгжилт 36.0 хувьтай байгаа нь нөлөөлсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 06/1477 дугаар албан бичгээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон хандив, тусламжийг хуульд заасны дагуу төвлөрүүлэх, цахим худалдан авалттай холбоотой зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь төсөв захирагч нар холбогдох хуулиудыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна. Иймд ТЕЗ-д хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 8,209.4 сая төгрөгөөр бууруулсан нь ААНОАТ-ын орлогыг 8,875.8 сая төгрөгөөр нэмж тодотгосонтой холбоотой байна.*
- 2. Анхны батлагдсан төлөвлөгөөг 59,108.1 сая төгрөг болгон тодотгож, гүйцэтгэлээр 77,279.2 сая төгрөгийг төвлөрүүлэн 18,171.1 сая төгрөгөөр давсан. Энэ нь тайлант онд нэг удаагийн шинжтэй 17,715.2 сая төгрөгийн орлого төвлөрсөнтэй холбоотой байна.*
- 3. Хүүгийн орлого 629.0 сая төгрөгийг ямар эх үүсвэрээс төвлөрүүлэх нь тодорхойгүй, бодит тооцоо, судалгаанд үндэслэлгүй баталсан байна.*
- 4. Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулаагүй ААНБ-аас хандив тусламж авахдаа сумын ОНХС-д төвлөрүүлээгүй, ААНБ болон ТББ-ын дансаар хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.*
- 5. Сумын цэвэр, бохир усны байгууламжуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь тодорхойгүй байдалтай байна.*
- 6. Сул орон тоо нь нийт батлагдсан орон тооны 11.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 74.1 хувь буюу 43 нь сумдын төрийн захиргааны албан хаагчийн орон тоо байна.*
- 7. ТЗАХ-д 5 жилд нэг удаа олгох 29 байгууллагын 93 албан хаагчид 724.2 сая төгрөгийн урамшууллыг олгохдоо урамшуулаас 72.4 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй олгосон.*
- 8. Тайлант онд ХХС-аас 2 сум 90.0 сая төгрөгийн зээл олгосон нь нийт батлагдсан төсвийн 4 хувь буюу зээл олголт хангалтгүй байна.*
- 9. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн 77.6 хувь буюу 248.8 сая төгрөг нь тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчил эзэлж байна.*
- 10. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 18 хөтөлбөр, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байгаа нь биелэлтийг 85.2 хувьтай дүгнэхэд хүргэсэн байна*
- 11. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажилласан ч, хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй байна.*

Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орлогын нэр төрлийг бодит тооцоо, судалгаанд үндэслэн эх үүсвэрийг тодорхойлон батлах;
2. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгээс хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутгаж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлж ажиллах;
3. Сумдын цэвэр бохир усны байгууламжийн эрх зүйн орчныг судлан аймгийн хэмжээнд нэгтгэсэн бодлого, стратеги хэрэгжүүлэн, зохион байгуулалтын боломжит хувилбарыг сонгож, зөв гарц шийдлийг олж шийдвэрлэх;
4. Төрийн албаны сул орон тоог 11.3 хувиас бууруулан 8 хувьд хүргэх;

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Үндэсний аудитын газраар дамжуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал-1:

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээл 2,275.9 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 90.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 4.0 хувь байна. Аймгийн хэмжээний 15 сумаас зөвхөн Цагаандэлгэр, Сайхан-Овоо сумд л хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгосон байна.

Засгийн газраас 2024 онд “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг зохион байгуулж, Дундговь аймагт шинээр 552 хоршоо байгуулагдан 480 хоршооны 1621 гишүүн малчдад 54,886.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосонтой холбоотой зээлийн хүсэлт ирээгүй.

Мөн “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-аар зөвхөн хоршоодод зээл олгохоор заасан байгаа нь сумдад шаардлага хангасан хоршоо цөөн байдгаас зээл олголт хангалгүй байна.

Санал: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулан зөвхөн хоршоонд бус, тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдэд зээл олгох боломжийг бий болгох талаар ҮАГ-аар дамжуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад уламжлахаар хүргүүлж байна.

Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн сайдад дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал-2:

Сангийн яамнаас 2024 оны татварын болон татварын бус орлогыг хянахдаа хүүгийн орлогыг 629.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Засгийн газарт төлөх урт хугацаат өр төлбөрийг төлөхөөр төлөвлөсөн байна. Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого хөрөнгийн орлогод хамаардаг бөгөөд уг хүүгийн орлогыг ямар эх үүсвэрээс оруулах нь тодорхойгүй, огт биелээгүй байна.

Санал: Эх үүсвэр тодорхойгүй, биелэх боломжгүй орлогыг нэмж хянахгүй байх, хэрэгжилтэд хяналт тавих тухай ҮАГ-аар дамжуулан Сангийн сайдад уламжлахаар хүргүүлж байна.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠓ᠨ